

ТААРУУ ОРЧУУЛАГЧ БОЛОХ БИ БЭЭР ОРЧУУЛГЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭН БОДОХ НЬ

Гэрэгэ / Gregory Pringle⁹⁵

Би 50 орчим жил орчуулгын ажил хийж байна. Орчуулгын сайн мууг яаж ялгах вэ, орчуулгын шинж чанар, холбоо хамаарлын талаар олж мэдэж, ажиглаж хуримтлуулсан бага сага туршлагадаа тулгуурлан энэ сэдвийг бичиж байна.

Гадаад хэл сурахад тус болох санаа

Бусад үеийнхэнтэйгээ адилхан, би дунд сургуульд гадаад хэл сурах үедээ орчуулгатай танилцсан юм. Тэр үед гадаад хэл заах нэг арга бол орчуулгыг загварчилж хийлгэдэг байлаа. Энэ талын дасгал бол үг нэг бүрийн утгыг нь ойлгож, мэдэж байгаа хэлзүйн бүтцийг ашиглан уялдаа, холбоотой өгүүлбэрийн утгыг мэдэж авахад тусалдаг байсан бөгөөд энэ нь яваандаа үгчилсэн орчуулга хийхэд хүргэдэг байв.

Энэ сурах аргад дутагдал байсан хэдий ч, ямартаа ч гэсэн гадаад хэлийг үндэс сууриар нь ойлгоход тустай арга байсан юм. Энэ нь гадаад хэлний хэлзүйн бүтцийг ерөнхийлөн ойлгох болон бага зэрэг болхи ч гэсэн гадаад хэлээр өгүүлбэр зохиох загвар болдог байсан. Тиймээс ахлах сургуульдаа би герман хэлний өгүүлбэрийн бүтцийн дарааллаар нь англи үгийг байрлуулан тогтоодог байсан билээ. Их сургуульд орсны дараа би япон хэлийг хэрхэн холбогддогийг ойлгохоор өгүүлбэрийг нь задлахад нэлээд цаг зарцуулдаг байлаа. Сурсан аргаараа япон хэлний бүтцээр англи хэлийг махчлан орчуулсан нь их хачин англи өгүүлбэр болдогсон. Харамсалтай нь би сурсан энэ зуршлаасаа одоо хэр нь ангижрахгүй байгаа болохоор, орчуулгын түвшингээ сайжруулахад үргэлж саад болсоор л байх юм.


Хаттори Широо



Хүмүүнлэгийн ухааны бакалаврын дипломын ажлынхаа хүрээнд би хэл шинжлэлийн хоёр өгүүлэл орчуулсан нь жинхэнэ орчуулга хийх, анх удаагийн ултай оролдлого болсон юм. Нэг нь структуралист (бүтэцзүйн хэл шинжлэлч) болох Хаттори Широо (Hattori Shirō)-гийн дайны дараа бичсэн зүйл байсан. Нэр томъёог нь оновчтой орчуулахаас бусад нь тийм ч хэцүү байгаагүй. Нөгөө нь уламжлалт хэлзүйч болох Хашимото Шинкичи (Hashimoto

⁹⁵ Австрали улсын иргэн, орчуулагч, судлаач

Shinkichi)-гийн 1930-аад оны үед бичсэн өгүүлэл байсан. Хашимото бол япон хэлзүйн дүрмийг зохиож энэ нь сургууль болон олон нийтэд хэрэглэгддэг болсноороо алдартай хүн. Би урьд нь тийм түг тагхийсэн, тодорхой мэдээжийн зүйлийг нэг бүрчлэн тайлбарлаж бичсэн өгүүлэлтэй таарч байгаагүй юм. Би



үүнийг орчуулах гээд өгүүлбэрээр нь задлан ялгаж, бүр махчлан орчуулдаг арга барилдаа орохоос өөр аргагүй болж билээ. Хэдийгээр өгүүлбэрзүйгээр нь задалж чадсан ч, англиар нь ойлгомжтой, оновчтой найруулгатай гэж санагдахаар тийм өгүүлбэр болгон орчуулж буулгах нь хамгийн хэцүү байсан. Одоо ч гэсэн тэр орчуулгыг харах болгондоо ичиж санаа зовдог.

Хашимото Шинкичи

Анхны ажил

Би Японд их сургуулиа төгссөний дараа Токио дахь Австралийн элчин сайдын яаманд орчуулагчаар орж анх удаа жинхэнэ орчуулагчийн ажил хийх болов. Тэр ямар ажил вэ гэвэл, үдээс өмнө Японы сонины өгүүллүүдийг англи хэл рүү орчуулж, үдээс хойш элдэв янзын материал орчуулдаг байсан. Орчуулсан сонины өгүүллүүдийг элчин сайдын яамны холбогдох тасгийн түшмэлүүд эх орныхоо яаманд лавлах материал болгон хэрэглэдэг байсан гэдэг юм.

Тэр үед, Австралийн элчин сайдын яамны сонины орчуулга Америкийн элчин сайдын яамныхаас нь хамаагүй сайн гэдгээр манайхан бахархдаг байсан. Америкийн элчин сайдын яамныхны орчуулсан орчуулга нь эхийг нь үгс, бүтцээр нь үгчлэн орлуулсан нь орчуулга гэж нэрлэхэд бэрх байсан юм. Харин энэ орчуулах арга бодит үндэслэлтэй байсан. Энэ юу вэ гэвэл, япон хэл мэддэг Америкийн түшмэл тэр орчуулгыг уншвал япон хэлний эх дээр юу хэлж байгааг нэлээн зөв зүйтэй ойлгож чаддаг байсан. Америкийн элчин сайдын яаманд эхийн утгыг нь бүдгэрүүлэх гоё англи хэл бус, махчилсан орчуулга хэрэгтэй байжээ.

Манай орчуулга Америкийн элчин сайдын яамныхаас илүү уншуургатай байсан ч гэсэн, заримдаа эх дээр байхгүй зүйлийг нэмж бичдэг байсан нь хачирхалтай. Жишээ нь, тухайн үеийн Австралийн ерөнхий сайд эдүгээ талийгаач болсон Боб Хоук байсан. Японы сонинд ер нь 豪ホーク首相 Gō Hōku shushō 'Австралийн Хоук ерөнхий сайд' гэж бичдэг байсан ч манай нэг орчуулагч маш хүндлэн эхэд байхгүй 'the Prime Minister of Australia the Hon. Robert James Lee Hawke' болох 'Австралийн ерөнхий сайд эрхэм Роберт Жээмс Лий Хоук' гэж орчуулж байсан.

Орчуулагчийн хувьд, би япон хэлний өгүүллийн агуулгыг аль болох харуулангаа зөв найруулгатай англи хэлээр илэрхийлэх зорилготой байсан. Миний хувьд тогтсон хэлбэртэй Японы сонины өгүүллийн найруулга уншихад дадлагажсан учраас, өмнө нь хийсэн орчуулгуудаасаа илүү өсөн дэвшиж байсан гэж бодож байна.

Орчуулга хийхдээ би хоёр зүйл дээр анхаарлаа хандуулж байлаа.

Нэгд нь, техникийн үг хэллэг, байгууллагын нэр гэх мэт нэр томъёог зөв оноон тогтмол хэрэглэх зорилготой байсан. Хамт ажиллагсдын аажмаар бүрдүүлсэн үгсийн тайлбар болон тэр үеийн хоёр хэлний нэр томъёо, үг хэллэгийн толь бичгүүд надад байнгын шаардлагатай хэрэгсэл минь болж байлаа.

Байгууллагын нэрийн энгийн жишээ гэвэл, тухайн үед 通商産業省 tsūshō sangyō-shō (товчилсон нэр 通産省 tsūsan-shō) гэдэг яам байсан. Тэр яаманд Ministry of International Trade and Industry ('олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам', товчилсон нэр 'MITI') хэмээх тогтсон англи нэр байсан юм. Орчуулагч дураараа Department of Trade and Industry ('худалдаа аж үйлдвэрийн хэлтэс') шиг өөр үгээр орчуулбал, уншиж буй хүмүүс өөр байгууллагыг зааж байгаа гэж бодно.



経済産業省

Ministry of Economy, Trade and Industry

METI

(2001 онд MITI-г 経済産業省 keizai sangyō-shō, нэрийг нь товчлон 経産省 keisan-shō, гэж өөрчлөн нэрлэсэн билээ. Англиар Ministry of Economy, Trade and Industry — 'эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам' ('METI') гэдэг.)



Техникийн үгсийн жишээ гэвэл, цахилгааны үүсгүүрт ашигладаг нүүрсийг монголоор 'эрчим хүчний нүүрс' гэдэг. Энэ төрлийн нүүрсийг японоор 一般炭 ippan-tan, бичсэнчлэн хэлбэл 'жирийн нүүрс' гэдэг. Англиар 'steaming coal' ('уур гаргах нүүрс') эсвэл 'thermal coal' ('дулааны нүүрс') гэж орчуулах хэрэгтэй.

Нүүрсээр ажилладаг цахилгаан станц (Wikimedia)

Тохирсон мэргэжлийн үгийг хэрэглэх нь чухал гэдгийг эрүүл ухаанаар ойлгох чадваргүй хүмүүс бас байгаад байдаг. Олон жилийн дараа нүүрсний төрлийг огт мэдэхгүй нэг компанийн орчуулагчийг япон, хятад түншлэгчдэд орчуулга хийж байгааг би сонссон билээ. Японоор 'эрчим хүчний нүүрс'-ийг 一般炭 ippan-tan ('жирийн нүүрс') гээд, хятадаар 动力煤 dòngli-méi ('хөдөлгөгч хүчний нүүрс') эсвэл 电煤 diàn-méi ('цахилгааны нүүрс') гэдэг. Харин тэр орчуулагч яг ижил утгатай гэдгийг анзаараагүй, хоёр талын үгийг махчлан орчуулж байсан. Тийм учраас, хэлэлцээ нь:

- *Япон тал:* Богино хугацааны эрчим хүчний нүүрсний зах зээлийг яаж харах вэ?
- *Хятад тал:* Бид нар эрчим хүчний нүүрсний үнэ нь бууна гэж бодож байна.

гэж ярих байсныг

- *Япон тал:* Богино хугацааны жирийн нүүрсний зах зээлийг яаж харах вэ?
- *Хятад тал:* Бид нар хөдөлгөгч хүчний нүүрсний үнэ нь бууна гэж бодож байна.



гэж ярьснаас болж талууд андуу ойлголцож магадгүй байсан. Аз болоход хоёр тал нүүрсний худалдааг нэвтэрхий мэддэг байсан болохоор эндүүрэл гараагүй.

Кобегийн ган төмрийн компанийн ган хайлах зуух (Steel 360)

Дашрамд хэлэхэд, коксжих нүүрсийг (заримдаа 'хүүрс' гэдэг хуучин монгол үгийг ч хэрэглэдэг) англиар 'coking coal' ('коксжих нүүрс') эсвэл 'metallurgical coal' ('металлургийн нүүрс'), японоор 原料炭 genryō-tan ('түүхий эдийн нүүрс'), хятадаар 炼焦煤 / 焦煤 liánjiāo-méi / jiāo-méi ('коксжих нүүрс / коксын нүүрс') эсвэл 冶金煤 yějīn-méi ('металлургийн нүүрс') гэдэг.

Хоёрт нь, эхийн бүтэц, үгийг хэтэрхий мөрдсөнөөс болсон эв дүйгүй өгүүлбэрийг жигдхэн уянгалаг өгүүлбэр болгох зорилготой байсан. Хашимото Шинкичигийн өгүүллийг орчуулсан үедээ ухаарсан шиг, япон хэлний өгүүлбэрийг англи хэл рүү орчуулахад байнга амаргүй байдаг. Махчлан орчуулсан болхи бүтцийг сайжруулж, өгүүлбэрийн хэлбэрийг англи хэлний хэлбэрт оруулж өөрчлөх шаардлагатай.

Жишээлбэл, тухайн үеийн томоохон асуудлын тухай Японы сонинд байнга гол санааг нь өмнө нь суурь мэдээлэл болгон тодотгол гишүүн өгүүлбэрийн хэлбэрээр оруулдаг. Жишээ нь, дараах тодотгол гишүүн өгүүлбэрээр эхэлсэн өгүүлэл их түгээмэл байсан:

- АНУ, Японы харилцаанд маш том маргаантай сэдэв болсон үхрийн мах, жүржийн асуудалтай холбогдуулан, Японы хөдөө аж ахуйн сайд өнөөдөр [...] гэж хэллээ.

Англи руу үгчлэн орчуулбал жаахан болхи өгүүлбэр болсон боловч би дандаа эхийн өгүүлбэрзүйн бүтцийг баримталж орчуулдаг байсан. Гэвч манай нэг орчуулагч үүнийг ингэж орчуулсан нь:

- Үхрийн мах, жүржийн асуудал АНУ, Японы харилцаанд маш том маргаантай сэдэв болжээ. Японы хөдөө аж ахуйн сайд өнөөдөр [...] гэж хэллээ.

Тийнхүү орчуулж тодотгол гишүүн өгүүлбэрийн болхи найруулгаас зайлсхийж чадсан. Харин энэ орчуулга сонины нэгдүгээр өгүүлбэрт бүх өгүүллийн гол санааг илэрхийлэх шаардлагатай гэдэг англи хэлний сэтгүүл зүйн гол дүрмийг зөрчсөн. Энэ өгүүллийн сэдэв 'үхрийн мах, жүржийн асуудал маш том асуудал болсон' бус, Японы хөдөө аж ахуйн сайд энэ асуудлын тухай саналаа илэрхийлсэн гэдэг нь чухал байсан.

Эдүгээ японы сонины бичих арга англи хэлний бичих аргыг авч хэрэглэснээр иймэрхүү маягийн бичих аргыг бага хэрэглэх болсон болохоор ийм орчуулгын асуудал бас ч багассан билээ.

Түүнчлэн 'хэт даврагч', 'алан хядлага', 'даяарчлал', 'дэлхийн дулаарал', 'цаг уурын өөрчлөлт' гэх мэт шинээр дэлгэрсэн илэрхийллүүдэд тодорхой, товчхон, ойлгомжтой дүйх үг олох нь бас чухал ажил байлаа. Энэ тал дээр өнөөгийн нэр томьёо, үг хэллэгийн толь бичиг ч маш их хэрэг болов.

1980-аад онд Японы засгийн газар эрчим хүчний хэрэглээг багасгахын тулд, эрчим хүч их хэрэглэдэг үйлдвэрлэлийн тоог цөөрүүлэх болон хаах бодлогыг батлан хэрэгжүүлсэн юм. Энэ үйл явцыг японоор 合理化 gōri-ka ('оновчтой болгох') гэж хэлдэг. Тухайн үед Англи, Америкт ч улсын үйлдвэрийн газар үр ашиггүй байсан учраас, нийт эдийн засгийнхаа үр ашгийг дээшлүүлэхийн тулд хувьчлах ёстой хэмээх үзэл хүчтэй өрнөж байлаа. Зах зээлийн үр ашиггүй талыг сайжруулахын төлөө, хүнд суртлыг халж, татварын хувь хэмжээг бууруулж, төрийн байгууллагуудын хувьд, илүүдсэн тасаг, ажлын байрыг цомхотхож, мөн компаний хувьд илүүдсэн үйлдвэр, ажлын байрыг ч үгүй хийх хэрэгтэй байсан. Энэ үйл явцыг ч японоор 合理化 gōri-ka гэж хэлдэг. Харин Англи хэл рүү 合理化 gōri-ka-г яаж орчуулах вэ гэдэг асуудал гарч ирсэн юм. Махчлан орчуулбал 'rationalise' ('оновчтой болгох') болно. Англи, Австралид эдийн засагчдын үзэл суртлыг шууд илэрхийлэхэд 'rationalise' ('оновчтой болгох') нь түгээмэл хэрэглэгддэг байсан. Харин Америк хүмүүст 'оновчтой болгох' гэдэг нь их хачин сонсогддог байсан юм шиг байгаа юм. Америкт дээрх санааг илэрхийлэхэд 'streamlining' ('шувтан хэлбэртэй болгох') гэдэг үг хэрэглэгддэг байсан. Шувтан хэлбэр гэдэг нь 'илүүдсэн юмыг хасах' гэдэг утгатай бөгөөд энэ "гоё" илэрхийлэл нь тэр үеийн нэр томьёо, үг хэллэгийн толь бичигт Америк маягийн 'streamlining' гэдэгтэй дүйж байсан. Харин би Австрали заншил ёсоор 'rationalise' ('оновчтой болгох')-ыг хэрэглэсээр л байв.

***Kūdōka*-гийн тухай**



Тухайн үед зардлаа хэмнэх зорилгоор японы компаниуд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ гадаад руу нүүлгэн шилжүүлэх хандлагатай болсон. Энэ үзэгдлийг японоор 産業空洞化 sangyō kūdōka ('аж үйлдвэрийн хоосрол') гэдэг үгээр хэлдэг. Манай нэг орчуулагч *kūdōka*-гийн хамгийн зөв зүйтэй дүйх үг бол 'deindustrialisation' ('үйлдвэргүй болох') юм хэмээх санал гаргасан. Одоо ч гэсэн аль алийг нь хэрэглэсээр л байна. Гэхдээ *kūdōka* уг нь Америкийн 'hollowing out' ('хоосрол') гэдэг үгийг япон хэл рүү орчуулсан хэлбэр юм. Харин тэр үеийн

дэлгэрсэн илэрхийлэл болох 'аж үйлдвэрийн хоосрол' нь илүү тохиромжтой байсан байж магадгүй.

Нэг үе би өөр орчуулагчидтай хамт орчуулгын судалгааны бүлэгт оролцож, орчуулагч хүний мэдэх ёстой арга барилд суралцдаг байлаа. Эндээс би өөрт тус болох олон шинэ юм сурч авсан юм. Одоог хүртэл Chris Holmes-ын инээдэмтэй анхааруулгыг мартаагүй явна. Япон хэлэнд ㊦ mo (монгол хэлний 'ч'-тэй адил) гэдэг үг маш их хэрэглэгддэг. Харин mo-г гарах болгонд 'also, even' гэж орчуулбал байнга хачин англи өгүүлбэр болдог. Chris Holmes япон хэлний өгүүлбэрийг орчуулахдаа mo-г тоохгүй байх тусам, mo чамд илүү их хайртай болно шүү гэж хэлж билээ. Энэхүү арга барил нь орчуулагчийг үгчлэн орчуулахаас холдуулах зорилготой байсан нь ойлгомжтой.

Цочирдол

Тэгээд нэг өдөр элчин сайдын яамны хөдөлмөрийн хэргийн зөвлөх намайг хажуу тийш нь дагуулж яваад, миний орчуулсан юмыг гоё англи хэл болон япон маягийн хачин англи хэлний холимог гэж хэлэхэд, энэ нь намайг маш их цочирдуулсан билээ. Зөвлөх орчуулсан өгүүллийг минь надтай хамт гүйлгэн уншингаа олон үг хэллэг зааж өгч анхааруулж билээ. Тус японы сэтгүүлчийн бичсэн өгүүллийн сэдэв бол Австралийн удирдлага болон ажилчдын хоорондох харилцааны систем ба нөхцөл байдлын тухай байсан юм. Зөвлөх нэг хэллэгийг зааж, энийг 'path of industrial harmony' гэж орчуулах ёстой гэсэн.

Үүнийг махчлан орчуулбал, industrial relations 'аж үйлдвэрийн харилцаа' гэсэн үг. Харин Англиар 'industrial relations' нь ажил олгогч ажилчдын (бодитоор хэлбэл компани болон үйлдвэрчний эвлэлийн) хоорондын харилцааг заадаг. 'Path of industrial harmony' ('ажил олгогч ба ажилчдын хоорондын эв найрамдлын зам') бол тэр үеийн үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний, аль болох ажил хаялтаас зайлсхийж ажил олгогчтой эв найрамдалтайгаар хэлэлцэх гэсэн бодлогыг хэлнэ. Тухайн үед Австралид байнга болдог байсан хөдөлмөрийн маргаан их алдартай байсан болохоор япон компаниуд Австрали руу хөрөнгө оруулах эсэхдээ эргэлздэг байсан нь шийдвэр гаргахад нь ч их муу нөлөөлж байсан юм.

劳使關係

✘ 'management-labour relations'

✔ 'industrial relations'

Тэр сэтгүүлч 'path of industrial harmony'-г яаж илэрхийлснийг, би яаж англиар бичсэнээ мартсан байна. Харин японоор 'industrial relations'-ыг 劳使關係 rōshi-kankei, яг 'ажилчин ажил олгогч хоёрын харилцаа' гэж хэлдэг учраас, би шууд 'management-labour relations' ('удирдлага хөдөлмөрчид хоёрын харилцаа') гэж махчлан орчуулсан байсан байх. Миний хувьд Австралийн уншигчдад япон хэлний хэлбэр, утгыг дамжуулах зорилготой байсан. Нөгөө талд манай зөвлөхийн үзэл бодлоор бол энэ орчуулга нь маш оновчгүй юм байсан бололтой. Яагаад

гэвэл, тэр зөвлөх япон сэтгүүлчийг Австрали руу явуулах ажилд оролцсон байж магадгүй бөгөөд Австралийн холбогдох хүмүүст ажлаа сайн хийж байгаа мэт сэтгэгдлийг заавал төрүүлмээр байсан байх л даа. Тэр зөвлөх 'Policy of peaceful labour-management relations' ('удирдлага хөдөлмөрчид хоёрын харилцааны энх тайванч бодлого') гэдэг япон маягийн хачин англи хэлийг Австралийн холбогдох хүмүүст лавтай үзүүлмээргүй байсан бололтой.

Тэгээд би нэг чухал юм ойлгосон билээ. Миний орчуулах арга Америкийн элчин сайдын яамныхнаас бараг ялгаагүй байсан гэж. Орчуулсан өгүүлбэрийг болхи бус болгохоор засаж, уншуургатай юм болгохын төлөө хүч чармайлт гаргасан ч, эхийн утгыг онож илэрхийлж, уншигчдадаа дамжуулахыг гол зүйл гэж бодож байсан юм л даа. Австралийн уншигчдад гоё хувцасласан мэт орчуулга бус, японы уншигчдад ямар сэтгэгдэл төрөхийг дамжуулах нь гол зорилго гэж бодож байсан хэрэг. Миний тэр санаа буруу байжээ.

Шантарч байсан надад өөрийгөө хүндэтгэх, өөртөө итгэх итгэл маань хэдэн жилийн дараа л өмнө нь төгссөн Австралийн их сургуульдаа эргэн очих үед анхны япон хэлний багштайгаа уулзсан тэр үед бүрмөсөн ул мөргүй алга болсон юм.

Тэр багш хэлэхдээ "Бид нар орчуулгын хичээл дээр чиний элчин сайдын яаманд байхдаа орчуулсан орчуулгыг дандаа хэрэглэдэг байсан" гэсэн билээ.

"Тийм үү?"

"Харин тийм. Чиний орчуулга эхтэйгээ ойролцоо байсан учраас япон хэл рүү орчуулахад нэлээд амархан байдаг байсан шүү" гэж билээ.

Австралийн оюутан англиас япон хэл рүү шууд орчуулж чадах англи хэлний текст нь багшийн хувьд маш сайн материал байсан ч, орчуулагчийн хувьд махчлан орчуулах хэмээх ноцтой дутагдлаасаа ангижраагүй гэсэн үг байсан.

Өөр ажил хийсэн минь

Би элчин сайдын яамны ажлаасаа гадна зарим өөр ажлын туршлагатай болсон. Токиогийн тусгай зөвшөөрөл (патент)-ийн өмгөөлөгчийн газарт түр ажил хийж үзэхдээ өөрөө патент орчуулаагүй боловч, хүний орчуулгыг засахдаа патентын орчуулгын нарийн шинж, чанга шаардлагыг ухаарсан юм. Патентын өгүүлбэр нь өөрсдийн зохион бүтээсэн зүйлийн онцлогийг нарийн тайлбарлахаас гадна хуулийн баримт бичиг болохоор эхээсээ яльгүй л зөрвөл өндөр хохирол гарахуйц болгодог.

Мөн нэг хэсэг хугацаанд би телевизийн студид мэдээллийг японоос англи руу орчуулж унших ажил ч хийж үзсэн. Мэдээлэл нь уншихад амархан, сонсоход аятайхан байх шаардлагатай. Хамт ажилладаг нэгэн япон хүний япон хэлийг түвэггүй, аятайхан англи хэл рүү хялбархан орчуулдаг чадварыг нь би машид биширсэн. Харин би шал ондоо. Би хичнээн хичээсэн ч загварчилдаг зуршлаасаа бүрэн ангижирч чадахгүй хэвээрээ л байсан юм.

"Жинхэнэ ажил"-аа олсон минь

Би бусдын нүднээс далд тийм ч их үнэлэгдэхгүй орчуулгын ажил хийж байхдаа, нийгэм дээр идэвх зүтгэл гаргаж улс болон байгууллагадаа их хувь нэмрээ оруулж байгаа хүмүүсийг хараад үргэлж атаархдаг байлаа. Тэгээд, хэдэн жилийн дараа би зүрхээ чангалж "жинхэнэ ажил" олж элчин сайдын яамаа орхисон юм. Олсон ажлын байр маань бол Токио дахь зах зээлийн судалгааны компанийн судалгааны ажил хариуцсан менежер. Хэлний тодорхой хэв маягийг дагаж бичсэн судалгааны тайлангаас гадна би үйлчлүүлэгчийнхээ төлөө Японы улс төр, эдийн засаг, нийгмийн талаар илтгэл бичдэг байв. Би энэ ажлынхаа төлөө нийтлэл орчуулж байсан боловч, эхийг нь нарийн орчуулах шаардлагаас чөлөөлөгдөж, үйлчлүүлэгчийг сонирхоно гэж бодсон янз бүрийн мэдээллийг тодруулахад зорьж ажилладаг байсан юм. Одоо бодоход энэ нь орчуулгын ур чадварыг минь сайжруулсан болов уу гэж бодож байна. Гэхдээ одоо ч гэсэн сайн мэдэхгүй л байна.

Хятад руу явсан нь



Дөрвөн жилийн дараа би Японы үзэсгэлэнт эргээс Хятадын өргөн уудам нутаг руу явахаар шийдлээ. Нэг жил хятад хэл сурсны дараа би нэг компанийн 'даргын туслахаар' ажиллах ажлын байр олов. Хятадад байхдаа нийтдээ дөрвөн компанид ажиллажээ. Бээжин, Хайнань, Макао, Шанхай, Япон, Монгол гэх мэт хэдэн газарт ажилладаг байсан. Миний дээд тушаалтан бол зарим нь хятад хүн, зарим нь япон хүн, нэг нь ирланд иргэншилтэй пакистан хүн байсан. Хэдийгээр Хятадад мэргэжлийн орчуулга руу хэзээ ч эргэж ороогүй боловч, би ажиллахдаа ихэвчлэн хятад-англи, япон-англи, англи-хятад, япон-хятад, заримдаа хятад-япон хэлээр орчуулах үүрэгтэй байсан юм.

Ажил дээрээ заримдаа гэрээ орчуулах шаардлагатай байлаа. Гэрээ орчуулахдаа мэргэжлийн сэтгэгдэл төрүүлэхүйц хуулийн үг хэллэгээр утгыг нь зөв илэрхийлэх хэрэгтэй байдаг. Азаар, миний орчуулга ихэнхдээ дотоод лавлагаанд зориулж байсан тул би хууль ёсны баримт бичгийн хамгийн хатуу чанга шаардлагаас чөлөөлөгдөж байсан гэхэд болно.

Зочид буудлын олон нийттэй харилцах ажил дээрээ би зар сурталчилгааны материал, үйлчлүүлэгчдээ зориулсан тайлбар, рестораны цэсийг хүртэл орчуулдаг байсан. Орчуулга төрөл бүрт тодорхой зорилго байдаг байсан юм. Зар сурталчилгааны материал зочид, үйлчлүүлэгчдийг татаж зочид буудлын үйлчилгээ, төхөөрөмж, цогцолборыг хэрэглүүлэх зорилготой байсан юм. Цэс уншуулж зочид буудлын ресторанд хоол идэх дур хүслийг нь татах хэрэгтэй байлаа. Өрөөний сэйф гэх мэтийн тоног төхөөрөмжийг яаж хэрэглэх вэ гэдэг тайлбарыг ойлгоход амархнаар илэрхийлэх хэрэгтэй. Энэ зорилгод үгчлэн

орчуулах нь тохиромжтой биш.

Үүнээс гадна өөр газарт, албан тушаалаа орхисон гадаад улс төрчдөд япон-англи хэлний орчуулгыг заримдаа надаар хийлгэдэг байсан. Нэг удаа гадаадын нэг улс төрч 'entrenched attitudes' гэдэг үг хэллэгийг хэрэглэсэн юм даг. Монгол хэл рүү үгчлэн орчуулбал 'бугшсан хандлага' гэдэг утгатай. Миний ой будилаагүй бол, тэр хүн улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд тухайн орны бага ястан хийгээд гадаад хүнийг ялгаварлан гадуурхах үзэл гэдэг утгаар хэрэглэсэн билээ. Англиар энэ төрлийн хандлагыг 'prejudice' ('эчнээ бодол, үнэмшил, үзлээр ялгаварлах') гэдэг. Харин тэр улс төрч 'prejudice' гэдэг үгээс илт зориудаар зайлсхийж байсан. Харамсалтай нь тэр үед би 'entrenched attitudes' ('бугшсан хандлага') хэмээх цээрлэн илэрхийлэх үгийг шууд санаж чадаагүй, яг 先入観 sennyūkan ('буруу төсөөлөл, атгаг санаа, итгэн үнэмшил') гэж орчуулсан билээ. Тэр хүний санааг бодвол, 先入観 sennyūkan гэдэг үг бол тохиромжгүй үг байсан байх. Google Translate харвал 'entrenched attitudes' ('бугшсан хандлага')-ыг японоор 定着した態度 teichaku shita taido ('байршсан хандлага') гэж байна. Харин энэ хэллэг ч тэр хүний санааг бүрэн зөв зүйтэй илэрхийлсэн үг гэж би одоо ч гэсэн бодохгүй байна.

Японы улс төрч ихэнх нь үлбэгэр, амт шимтгүй, хэвд оруулсан үгээр ярьдаг онцлогтой, үүнтэй харьцуулбал англи хэлтэн улс төрч ерөнхийдөө хурц, тодорхой ярих хэвшилтэй. Нэг удаа, миний орчуулсан үг тус гадаад улс төрчийн хэлсэн утгыг нь зөв дамжуулж байгаа эсэхийг батлахаар орчуулсан агуулгыг буцааж англи хэл рүү орчуулсан юм. Тэр хүн "би энэ хэлбэрээр илэрхийлээгүй шүү" гэсэн боловч утгыг нь ойролцоо гэж хүлээн зөвшөөрсөн юм. Улс төрчийн хэллэгийн нарийн ялгааг онож илэрхийлэх нь хэцүү болохоор энэ бол орчуулагчийн чадварыг сорьдог ажил. Тийм болохоор би олон улсын удирдагчдад орчуулга хийх хүмүүсийн орон тоонд ажилламааргүй санагддаг юм.

Өөр зүйлийн орчуулга

Хожим нь би миний ажиллаж байсан худалдааны компаний даргад салбарын мэдээ (шаардлагатай бол улс төр, эдийн засгийн мэдээ гэх мэт) цуглуулж өгөхөөс гадна англи, япон хэлнээс хятад хэл рүү орчуулах ажилд томилогдсон. Энэ нь маш их хэцүү үүрэг байлаа. Би эцэст нь Google Translate маш ихээр ашиглаж, түүний муу орчуулгыг нь засахдаа их цаг зарцуулдаг байсан юм. Би өөрийнхөө орчуулгаар огт бахархахгүй. Манай компанид зуны амралтаар нь хөлсөлсөн их сургуулийн оюутнуудын хийсэн гялзалзсан орчуулгатай харьцуулбал миний орчуулга маш муу байсан санагддаг юм.

Харин би туршлага багатай залуу хятад оюутнуудаас хэд хэдэн давуу талтай байсан. Үүнд:

1. Би хамгийн чадварлаг оюутнуудаас ч илүү англи хэлээр төгс ойлгодог байсан. Нэгэн оюутан 'wet weather' (бороотой цаг агаар)-ыг 'чийгтэй цаг агаар' гэж орчуулсныг санаж байна. Энэ нэлээд энгийн жишээ боловч би зарим томоохон мэдээллийн агентлагаас гарсан орчуулгад ч алдаа гардаг гэдгийг олж мэдсэн.

2. Цаг хугацаа өнгөрөхөд би мэдээн доторх мэдээллийн ихэнх нь суурь мэдээлэл эсвэл нөхөөс байдаг гэдгийг мэдсэн. Жишээ нь, хятад хэл рүү орчуулахдаа би 'Австралийн зүүн хойд нутагт оршдог Квинсланд муж' гэх мэт олон нийтэд зориулан хүмүүсийн төлөө тайлбарласан мэдээллийг уул уурхайн салбарынхан нийтээрээ мэддэг зүйл учраас, энэ мэт мэдлэгийн зүйлийг орхидог байсан юм. Иймэрхүү байдлаар миний орчуулгын найруулга тааруухан байсан ч үнэн зөв, цэгцтэй болдог байв.

Гадаад хэл рүү орчуулга хийхдээ, өмнө хуримтлуулсан мэдлэгээ дайчлан ажиллах нь орчуулах чадварт тийм ч их нэмэр болдоггүй гэж би мэдсэн. Гадаад хэлнээс төрөлх хэл рүүгээ орчуулбал үгсийн сан, илэрхийлэх чадвараа дээшлүүлэх илүү их боломжийг олгодог.

Бүтэлгүйтэл

Он удаан жил бүтэлгүйтэх явдал гарсаар л байлаа. Аман орчуулга хийхдээ тэвдэж сандрахдаа алдаа гаргадаг байснаас гадна, хэлмэрч хийхдээ төдийлөн сайн биш байсан билээ. Бичгийн орчуулга хийхэд ч дутагдалтай зүйл байсаар байсан санагддаг.

Нэг удаа таньдаг япон эмэгтэй нөхөр нь болох хятад уран бүтээлчийн бүтээлийн цомгийн оршлыг орчуулахыг надаас хүсэж хятад хэл дэх эх зохиол, япон хэлний орчуулгыг хоёуланг нь надад өгсөн. Хятад хэлний эх зохиолын утга нь овоо тодорхой байсан боловч би яаж тохиромжтой сайн найруулгатайгаар орчуулахаа мэдэхгүй байлаа. Миний хувьд уран бүтээлчийн эхнэрийн орчуулсан япон орчуулга нь хоёр хэлний хоорондын ялгааг хүчээр тохируулсан, болхи бүтцээр дүүрэн, тойруу замаар найруулсан, хангалтгүй өгүүлбэр байсан. Би орчуулж дуусгаад түүнд өгсний дараа тэрээр сураггүй боллоо. Хэсэг хугацааны дараа нэг япон найз маань надад тэр эмэгтэй миний орчуулгад тун сэтгэл дундуур байсан тухай ярьж билээ. Миний бодлоор, орчуулга минь илүү хялбар, урлах мэдрэмж дутуу байсан байж магадгүй. Харамсалтай нь тэр эмэгтэй надад ямар ч үнэлэлт дүгнэлт тайлбар өгөөгүй болохоор, би жинхэнэ шалтгааныг хэзээ ч мэдээгүй бөгөөд тэр байдлаас орчуулах түвшингээ ахиулах боломжийг авч чадаагүй юм.



Газар хөдлөлтийн дараах бохир усны шугам сүлжээ

Саяхан би япон үйлчлүүлэгчийн хүсэлтээр газар хөдлөлтийн дараа бохир усны шугам сүлжээг саадгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар хоёр орчуулгын ажил хийсэн юм. Эхнийх нь миний үйлчлүүлэгчийн олон нийтэд зориулж хэлэх үг байсан. Би эхийн үгс, бүтэцтэй нь ойролцоо маягаар орчуулсан нь үйлчлүүлэгчид овоо таалагдсан. Дараагийнх нь эхнийхтэйгээ нь ойролцоо боловч, зарлал учраас зорилго нь маш өөр байсан. Олон нийтийн зарлалын зай хязгаартай, хялбар ойлгогдох үг хэрэгтэй болохоор, би сонгосон үгийг нь хялбарчилж үгийн тоог нь ч багасгаж

сайжруулсан. Харин энэ нь үйлчлүүлэгчийн сэтгэлийг зовоож эхийн орчуулгын хэлбэрт нь буцаан оруулах гэж шөнөжингөө нухсан гэнэ. Энэ удаад би уг нь эх зохиолыг сохроор дагадаг муу зуршлаасаа зайлсхийх ур дүй эзэмшсэн ч, инээдэмтэй нь үйлчлүүлэгчийнхээ сэтгэлийг хангаагүй хэрэг. Үйлчлүүлэгч харваас миний зайлсхийгээд байгаа тэр орчуулах аргыг хүсээд байсан юм.

Миний сурсан зүйл

Олон жилийн туршлагатай болохоор намайг орчуулгын талаар төгс гэж бодож байж магадгүй, харамсалтай нь тийм биш юм. Гэхдээ олон жилийн турш ингэж байнгын орчуулгын ажил хийх явцдаа миний олж мэдсэн, ойлгосон зүйлсийн заримыг нь доор дурдъя. Үүний ихэнх нь цэвэр эрүүл ухаан боловч 'орчуулга судлал'-ын салбарт бага зэрэг хамааралтай байж болох юм.

1. Орчуулга бол зорилгод чиглэсэн үйл ажиллагаа, зөвхөн зорилгын талаас ойлгох боломжтой.

Туйлын оновчтой зөв орчуулга гэж байдаггүй. Зөвхөн зорилгодоо нийцсэн орчуулга гэж бий. Орчуулгыг ихэвчлэн 'хууль ёсны орчуулга', 'утга зохиолын орчуулга' гэж хуваадаг. Энэ нь зөвхөн зорилгоор нь хувааж байгаа хэрэг юм.

- Хэрэв АНУ-ын элчин сайдын яам эх зохиолыг үгчлэн орчуулсан, эхтэй тодорхой холбоотой орчуулгыг хүсэж байвал, энэ нь зайлшгүй шаардлага;
- Хүмүүсийг ятгах, сэтгэгдэл төрүүлэх шаардлагатай бол, хүмүүсийг ятгах үгсийг жигд хэрэглэх ёстой;
- Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд сонирхогчийн сэтгэлийг нь татам болгох зорилготой орчуулгыг сэтгэл татам байдлаар танилцуулахаар бэлтгэх ёстой;
- Хэрэв орчуулга нь улс төрийн шаардлагыг хангах хэрэгтэй бол таарсан үгсийг хэрэглэх ёстой. (Жишээ нь, Хятад улсын хилийн чанадад зориулсан мэдээллийн нэг асуудал бол гадаадад байгаа уншигчдад сэтгэгдэл төрүүлэхийн зэрэгцээ, улс төрийн шаардлагыг хатуу баримтлах гэдэг хоёр зорилго нь харилцан зөрчилддөг);
- Хууль эрх зүйн орчуулга нь, агуулга нь хуулийн цоорхойгүй, эрх зүйн баримт бичгийн хэв маягтай, хууль дээр няцаагдашгүй байх ёстой;
- Улс төрчдөд зориулсан орчуулга нь тэдний улс төрийн асуудалд яаж нөлөөлөхийг мэдрэх мэдрэмжтэй байх хэрэгтэй;
- Дипломатын орчуулга нь дипломат хэлбэрийн онцлог хэлбэр, хэлийг дагаж мөрдөх ёстой;
- Гол мэдээллийг шаарддаг орчуулга нь үнэн зөв, хэрэгцээг хангадаг байх ёстой. Хичнээн ч сайхан өнгөлсөн орчуулга байсан ч тоо баримт алдаатай байвал хэрэгцээ хангахгүй муу орчуулга болно;
- Уран зохиолын орчуулга нь уншигчдад уран сайхан мэдрэмж төрүүлэх зорилготой. Гүн ухаан сэтгэлзүйн сонгодог зохиолыг сонгодог зохиол шиг уншигддаг, адал явдалт зохиолыг адал явдалт зохиол шиг уншигддаг, хошин зохиолыг хошин шог зохиол шиг уншигддаг байхаар орчуулах хэрэгтэй;

Александр Поуп (Wikipedia)



- Уран зохиолын орчуулгын шаардлага мөнхөд тогтоосон зүйл биш. XVIII зууны английн яруу найрагч болох Александр Поуп (Alexander Pope) Хомер (Гомер)-ын туулийг тэр үеийн шүлэглэсэн хэлбэрээр орчуулж, үг нэмж, хасч, сольсон боловч хүмүүст сайшаагдсан байдаг. Харин өнөө цагийн хүмүүс эртний үеийн хүмүүсийн хэрэглэдэг байсан бодит үг хэллэг, найруулгыг хүсэх болсон байна.
- Хувиараа өөрийнхөө хэрэгцээг хангах орчуулга нь хэвлэлээс гаргаж олон нийтэд түгээх орчуулгаас өөр "уншигчидтай" учраас, тавих шаардлага ч мөн тийм ажээ.
- Түүхэн баримтын орчуулга, ихэвчлэн тайлбартай, эрдэм шинжилгээний орчуулга нь утга зохиолын найруулгатай байх шаардлагагүй. Утга зохиолын орчуулга нь эрдэм шинжилгээний найруулгатай байх ч албагүй. Гэхдээ энэ хоёрын аль аль нь зохицолдолгоотой байх нь тохиромжтой.
- "Бяцхан хунтайж" шиг үлгэрийн эх зохиолыг бүгдийг нь хэвээр нь орчуулсан, бас хүүхдүүдэд зориулсан үлгэр шиг орчуулсан хоёр маягийн орчуулга байдаг. Хүүхдүүдэд зориулж орчуулахад мэдээж үг найруулгыг өөрчлөх шаардлага арвин гардаг.
- Киноны үгийг хоёр хэлбэрээр орчуулдаг. Нэг нь үгийг нь хөрвүүлээд дуу оруулагчаар хэлүүлэх, нөгөө нь хадмал орчуулга хийгээд дэлгэцний доод талд хадаж гаргах. Энэ хоёр хэлбэр хоорондоо шал өөр. Дуу оруулагчийн хэлэх үг эх үгтэй голдуу адилхан хугацаанд хэлж амжих шаардлагатай. Орчуулагч үгийнхээ утгыг харьцангуй чөлөөтэй орчуулах боломжтой байдаг. Харин хадмал орчуулга нь дэлгэцэд гардаг үсгийн тоо, гарах хурд гэх мэт хатуу шаардлагатай. Хатуу хязгаарлалтын дотор эх үгийн утгыг товч тодорхой, илэн далангүй, шууд ойлгож чадах үгээр дамжуулах хэрэгтэй.
- Харамсалтай нь бодит байдалд орчуулга хийх зорилго нь уншигчдад тохиромжтой орчуулга бус, хагас дутуу гадаад хэл мэддэг үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангах хэрэгтэй байх тохиолдол байдаг. Өмнө өгүүлсэн япон үйлчлүүлэгч шиг. Ялангуяа ийм асуудал Японд түгээмэл байдаг.
- За, нөхцөл байдлыг минийхээр ойлгосон байх аа ...

2. Хэдийгээр орчуулгын программ зохион бүтээсэн ч орчуулга бол хүний төлөө хийсэн хүний үйл ажиллагаа юм.

Хамгийн гол нь орчуулга бол орчуулагчийн орчуулахдаа хийсэн сонголтын үр дүн. Тэр сонголтууд нь орчуулгын ерөнхий хэв маяг, өнгө аяс, нарийвчлалтай байдлыг тодорхойлдог.

Орчуулагчийн олон нөхцөл байдал нь орчуулгын чанарт нөлөөлнө.

- 1 Орчуулагч хэр зэрэг эх зохиолоо ойлгож байна вэ? Орчуулагчийн үл ойлгосон байдлаас болж орчуулгын чанар муу болох нь түгээмэл байдаг.
- 2 Орчуулагчийн орчуулга, тухайн чиглэлийн туршлага. Орчуулагчид тухайн сэдвийг ойлгох, үгийн олон утга, найруулгын хэв маягийг олж авахдаа маш их цаг зарцуулах шаардлага тулгарна.
- 3 Орчуулагч арвин баялаг үг, үгийн хэрэглээтэй байвал зохино. Зарим хүмүүс сайн найруулга, баялаг үгийн сан, үг хэллэгийг мэдрэх мэдрэмж, зохиогчийн ертөнцийг үзэх үзэл зэрэг янз бүрийн хэлбэрийн уран зохиолыг судалж сайн орчуулагч болдог. Зарим хүмүүс арай үүнд хүрдэггүй.
- 4 Орчуулагчийн өвөрмөц шинж. Орчуулагч нар эх зохиолыг орчуулах өөрийн гэсэн олон аргатай. Сонины нийтлэлийг орчуулахдаа өөрийнхөө аргыг хэрэглэдэг байсан манай элчин сайдын яамны орчуулагч гэх мэт, бүх орчуулагчдад өөрийн арга барил байдаг. Энэ нь орчуулгын хэв маягт ихээхэн нөлөөлөх боломжтой.
- 5 Орчуулагчийн суурь хэвшил. Орчуулагч нарын "автоматаар" орчуулах зуршил нь тэдний сургуульд анх гадаад хэл сурч эхэлсэн үеэс л тогтдог гэж би бодож байна. Харин ийм зуршлаасаа ангижрахад хэцүү.

3. Ихэнх орчуулга чухамдаа үгчилсэн орчуулга байдаг.

Махчлан орчуулахаас зайлсхийж, аль болох эх зохиолынх нь утгыг тэр хэвээр нь уншигчдад өгөх ёстой гэж байнга уриалдаг боловч бодит байдалд эх зохиолын үгсийн сонголт, үгсийн дараалал нь бүхий л орчуулгын эхлэл юм.

Зөвхөн дадлагагүй орчуулагч эх зохиолыг анх удаа хараад үг тус бүрийг зөнгөөрөө орчуулдаг юм биш. Туршлагатай орчуулагч ч бас ингэдэг. Учир нь эх зохиолын түүхий эд бол үг юм. Бодит байдалд эх зохиолын үгсийн сонголт, үгсийн дараалал нь бүх орчуулгын эхлэл юм. Ур чадвараа дээшлүүлэхийн тулд орчуулагч эхийн нарийн хэлбэрт хэт их санаа зовохоос зайлсхийх хэрэгтэй. Энэ зуршлаа нэг шөнийн дотор засаж чадахгүй. Жишээ нь, япон хэлний ㊦ тог автоматаар үгчлэн орчуулахаас зайлсхийхтэй адил. Нарийн бүтцийг тогтсон хэлбэрээр орчуулахаас зайлсхийх гэдэг энгийн зүйлээс эхэлж болно. Мэдээжийн хэрэг зарим хүмүүс бичих чадвартай, тэдэнд сэтгэл татам уянгалаг сайн зохиолыг бичихэд бусдаас бэрхшээл бага байдаг. Гэхдээ ямар ч орчуулга хийхэд бүтэн зохиол бичихтэй адил, хүчин чармайлт хэрэгтэй.

Цогц хүрээний судалгаа нь орчуулгын өвөрмөц онцлогийг тодорхойлж, орчуулга нь эх зохиолоосоо хэрхэн ялгарч байгааг тодорхойлж, орчуулагчийн ур чадвар, дадал хэвшил, найруулгын өвөрмөц шинжийг тодорхой болгох боломжтой байдаг гэж би бодож байна.

(Аман орчуулга нь дээрх аргаас онцгой байдаг. Хэлэлцээр болон тухайн газар дээр шууд орчуулга хийхдээ орчуулагч үг тус бүрийн утгыг бус, ерөнхий мэдээллийг нь дамжуулдаг, үг, бүтцийг орчуулах аргаас зайлсхийх шинжтэй учраас аман орчуулга хийх туршлага нь бичгийн орчуулагчдад ч тустай байна.)

4. Стандарт болсон олон улсын нэр томъёоны үүрэг бусдад анзаардагддаггүй.

Орчин үеийн "орчуулга" гэгч юм ихэнх нь стандартчилсан нэр томъёог мэдэх гэсэн үг. Дэлхийн гол гол хэлний орчуулагчид ямагт зөвхөн бэлэн үгийг л орлуулах хэрэгтэй. Жишээ нь, 'economic' гэдэг үг европын хэлээр économique (Франц хэл), ökonomisch, wirtschaftlich (Герман хэл), económico (Испани хэл), экономический (Орос хэлээр) гэх мэт тогтсон дүйх үгтэй. Азийн хэлэнд ч 經濟(的) keizai(-teki) (япон хэл), 經濟 / 经济 jīngjì (хятад хэл), 간결한 gangyeolhan (Солонгос хэл) гэх мэт үг байна. Монгол хэлэнд түүхээс шалтгаалан "эдийн засгийн" (Монгол), "аж ахуйн" (өвөрмонгол) хэмээх хоёр үг байна.

Харин 150-хан жилийн өмнө орчуулга хийдэг хүмүүст ийм тогтсон нийтлэг үг байдаггүй байсан байна. Европын хэлнээс бусад хэлэнд "эдийн засаг" гэдэг үгийн тогтсон дүйх үг байдаггүй байсан. Орчин үеийн болгон шинэчлэх (现代化) буюу өрнөджилтийн (西方化) явцын дунд XIX зууны орчуулагчид дүйх үгийг цоо шинээр зохиож, одоогийн үгийн сангийн суурийг тавьсан юм. Тиймээс, өнөөгийн орчуулагчийн хувьд, жишээ нь "Свахили хэлээр 'эдийн засгийн' гэдэг санааг яаж илэрхийлэх вэ?", "Свахили хэлээр 'эдийн засгийн' гэдэгтэй дүйх үг юу вэ?" гэдэг хоёр шал өөр асуулт болно. Одоо стандартчилсан шинжлэх ухаан, технологиос гадна спортын салбарт ч олон улсын нэр томъёог маш нийтлэг хэрэглэх болжээ. Тиймээс "орчуулга" гэдэг нь ухаан сийлэх бус, цээжилсэн дүйх үгээ гарган оноох эсвэл толь бичиг харахтай адил амархан ажил болсон. Компьютерын орчуулга ч бас энэ орлуулсан, дүйлгэсэн нэр томъёод маш их түшиглэдэг.

Төгсгөл

Сүүлийн хэдэн арван жилд орчуулгазүйн салбарт олон шинэ хандлага дэлгэрч ирлээ. Үүний дотор цогц хүрээний судалгаа ч их байна. Эдгээр нь шинэлэг ололтууд болсон юм. Америкийн хэлшинжлэлч Н.Чомскийн онол бол бодит зүйл бус оюун ухааны хийсвэр объектыг судлах зорилготой. Олон судлаач Н.Чомскийн "төгс төгөлдөр яригч, сонсогч"-той адилхан, "төгс орчуулагч" байдаг гэж бодож байгаа юм шиг байна. Харин миний хувьд "төгс орчуулагч" буюу өв тэгш орчуулагч гэдэг юм байдаггүй, эхийг орчуулах төгс арга ч бас байдаггүй. Ихэнх орчуулга зорилгоосоо хамаардгийг бодолцох хэрэгтэй гэж үзэж байна.